

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-222 дугаар тушаалаар “Ховор маргад” ХХК-д Богдхан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд 1.18 га газар ашиглах эрх аялал жуулчлалын зориулалтаар олгосон.

“Нью тур” ХХК-ийн гаргасан нэхэмжлэлээр Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 719 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 788 дугаар магадлалаар А-222 дугаар тушаалын “Ховор маргад” ХХК-д холбогдох хэсгийг болон газар ашиглах гэрчилгээний хавсралтыг хариуцагчаас дахин шинэ акт гартал 6 сарын хугацаатай түдгэлзүүлж шийдвэрлэсэн, уг шийдвэрт хэргийн оролцогчоос гаргасан гомдлыг Монгол Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 80 дугаар тогтоолоор хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.

Хариуцагчаас шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тул “Ховор маргад” ХХК 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр дахин шинэ акт гаргуулах хүсэлт гаргахад Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас “тухайн маргааныг шүүх шийдвэрлэсэн тул яамнаас шийдвэр гаргах боломжгүй” гэсэн хариу өгч, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/277 дугаар тушаалаар газар ашиглах эрх олгосон тушаалын “Ховор маргад” ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсон байна.

Нэхэмжлэгчээс “...”Ньютур” ХХК нь захиргааны хэргийн анхан шатны шүүхэд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-222 дугаар тушаалыг илт хууль бусад тооцуулах нэхэмжлэлийн шаардлага гаргасны дагуу шүүхийн шийдвэр, магадлалаар дээрх тушаалын “Ховор маргад” ХХК-д холбогдох хэсэг, газар ашиглах гэрчилгээний хавсралтыг тус тус 6 сарын хугацаатайгаар түдгэлзүүлж шийдвэрлэсэн. Тус шийдвэр, магадлал хуулийн хүчин төгөлдөр болсон тул хариуцагч Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад хандан шинээр захиргааны акт гаргаж өгөх”-ийг хүссэн боловч хариуцагч шүүхийн шийдвэрийг сайн дураараа хэрэгжүүлэх ажиллагаа хийгээгүй, шүүхээс шинээр захиргааны акт гаргахыг даалгасан байхад хариуцагч шүүхийн шийдвэрийг мушгин гуйвуулж тус газар ашиглах эрхийн маргааныг шүүх эцэслэн шийдвэрлэсэн мэтээр хариу өгсөн. Уг маргааныг шүүх эцэслэн шийдвэрлээгүй бөгөөд харин захиргааны байгууллагын шийдвэрийг шүүх эцэслэн шийдвэрлэх боломжгүй байх тул тухайн захиргааны байгууллагад шүүхээс тогтоосон 6 сарын хугацаанд Захиргааны ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлд заасан нөхцөл байдлыг тогтоох ажиллагааг дахин явуулж мөн хуулийн 42 дугаар зүйлд заасан сонгох боломжийн хүрээнд шийдвэр гаргах боломжийг олгосон шийдвэр байхад хариуцагч байгууллагаас шүүхийн шийдвэрийг анхнаасаа мушгин гуйвуулж тайлбарлан дээрх ажиллагаа явуулахаас үндэслэлгүйгээр татгалзаж, хэрэгжүүлэлгүйгээр “Ховор маргад” ХХК-ийн газар ашиглах эрхийг бүхэлд нь хүчингүй болгож, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн...” гэх агуулгаар маргажээ.